

ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ҮНЭ /6-р сарын 25-наас 7-р сарын 30-ны байдлаар, төгрөгөөр/

№	Барааны нэр, төрөл	VI/25	VII/02	VII/09	VII/23	VII/30
1	Гурил, I зэрэг, кг	1000	1000	1000	1000	1000
2	Хонины мах, кг/ ястай/	7500	7500	7500	7500	7000
3	Үхрийн мах, кг /ястай/	10000	9000	9000	9000	8500
4	Ямааны мах /ястай /	6500	6500	6500	6500	6000
5	Элсэн чихэр, кг	1700	1700	1700	1700	1600
6	Цагаан будаа, кг	2150	2150	2150	2150	2150
7	Шингэн сүү, л	800	800	800	800	800
8	Ямааны ноолуурын үнэ 1 кг- цагаан	60000	60000	зарагдаагүй	зарагдаагүй	зарагдаагүй
9	- Бор ноолуур	60000	60000	зарагдаагүй	зарагдаагүй	зарагдаагүй
10	Бензин, А-80, 1 литр	1570	1570	1570	1570	1570
11	Бензин, А-92, 1 литр	1690	1690	1690	1690	1690
12	Дизелийн түлш, 1 литр	1790	1790	1790	1790	1790

Гол нэрийн барааны үнийн 7 хоногийн мэдээгээр аймгийн төвд 2014 оны 6-р сарын 25-наас 2014 оны 7-р сарын 30-ны хооронд “Алтан тариа” ХК 1-р гурил, цагаан будаа, шингэн сүү, шатахууны ханш тогтвортой байсан бол хонь үхэр, ямааны ястай мах, элсэн чихрийн үнэ өөрчлөгдөж, аймгийн төвд ноолуур 7-р сарын 9-нөөс эхлэн зарагдахгүй байна.

Махны үнэ. 7-р сарын 23-ны өдөр хүртэл хонины ястай мах 1 кг нь 7500 төгрөг байсан бол 7-р сарын 30-наас 6,7 хувь буюу 500 төгрөгөөр буурч 7000 төгрөг болсон. Үхрийн ястай мах 7-р сарын 02-ноос 7-р сарын 23-ныг хүртэл 3 долоо хоногийн турш 9000 төгрөгийн байснаа 7-р сарын 30-наас 8500 төгрөгийн ханштай болж 500 төгрөгөөр буурсан. Ямааны ястай мах мөн 7-р сарын 30-аас 6000 төгрөг болж өмнөх 7 хоногийн үнэнээс 7,7 хувиар буурав.

Гурил, элсэн чихэр, цагаан будаа. Элсэн чихэр 1 кг нь 7-р сарын 30-наас 1600 төгрөг болж өмнөх 7 хоногоос 100 төгрөгөөр буурав. “Алтан тариа” ХК-ийн 1-р гурил, цагаан будааны үнэ сүүлийн 5 долоо хоногийн турш тогтвортой байна.

Шингэн сүү. Энэ хугацаанд 1 литр шингэн сүүний үнэ 800 төгрөгийн ханштай байна.

Ямааны ноолуур. 7-р сар гартал 60000 төгрөгийн ханштай байсан ямааны ноолуурын арилжаа 7-р сарын 10-аас зогссон байна.



